

## “ХХ ЗУУНЫ МОНГОЛЫН ТҮҮХИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” СЭДЭВТ СЕМИНАР-ЯРИЛЦЛАГА БОЛОВ

М.Баттөмөр

Монгол Улсын Их Сургууль, Түүхийн судалгааны хүрээлэн

МУИС-ийн НШУС-ийн Түүхийн тэнхмээс зохион байгуулж, 2008 оны VI сарын 3-нд “ХХ зууны Монголын түүхийн тулгамдсан асуудал” сэдэвт онол семинар-ярилцлага хийв.

Семинарт МУИС, УБИС-ийн профессор багш нар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид оролцов. Тус семинарийг нээж, академич Ж.Болдбаатар хэлсэн үгэндээ: эл арга хэмжээний гол зорилт бол 2008 оны IX сард академич Ш.Нацагдоржийн мэндэлсний 90 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний хурлын бэлтгэл ажилтай холбоотой юм. Уг нь бид Түүхийн хүрээлэнтэй хамтран “ХХ зууны Монголын түүхийн зангилаа асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг VI сард зохион байгуулахаар бэлтгэж байсан юм. Гэтэл Ш.Нацагдорж багшийн ойд зориулсан олон улсын хурал хийх шийдвэр гарсан. Ийм учраас хөрөнгө мөнгөний бололцооноос болж, эх хурлыг хойшлуулан IX сард академич Ш.Нацагдоржийн ойд зориулан хийхээр Түүхийн хүрээлэнтэй тохиролцсон болно. IX сарын хурлыг Бүгд хуралдаан, салбар хуралдаантайгаар зохион байгуулна. Нэг салбар хуралдаан нь “ХХ зууны Монголын түүхийн зангилаа асуудал” сэдэвтэй байх юм. Тэгэхлээр энэ удаагийн онолын ярилцлагыг тус салбар хуралдаанд бэлтгэхэд зориулж байгаа болохыг онцлон тэмдэглэв.

Онолын семинар-ярилцлагын гол илтгэлийг МУИС-ийн Түүхийн тэнхмийн багш, доктор (Ph.D), дэд профессор С.Отгонжаргал хийв. Тэрбээр дараах асуудалд гол анхаарлаа төвлөрүүлэв.

Монголын түүхийн судалгаа олон улсын төвшинд ойртох чиглэлийг барин хөгжиж байна. Түүхийн шинжлэх ухааны хөгжлийн тодорхой үе шатанд түүхийн тухай мэдлэгийг шинэ зарчим, үндэслэлүүдэд тулгуурлан системчлэх шаардлагатай байна. Үүнд:

- Өдгөө түүхийн шинжлэх ухааныг онолд суурилуулахдаа-Мета онолын судалгааг чиг баримжаа болгох, үүнээс улбаалан түүх мөн мета чанартайг анхаарах;

- түүхийг субстанцлаг чанарт нь суурилуулах;

- түүхэн оршихуйг гурван цагийн хэлхээ холбоо, нэгдэлд нь буюу өнгөрсөн, эдүгээ, ирээдүй, нэгдмэл гэж үздэг историзмийн зарчимд нь тулгуурлах;

- түүхэн судалгааны контекстэнд дулдуйдах;

- өнгөрснийг өнөөгийн эрин үеийн шалгуураар шалгах явдалд шүүмжлэлтэй хандах;

- түүхэн үйл явцыг үйл явдал гэж ухварладаг ойлголтод шүүмжлэлтэй хандах зэрэг зарчим үндэслэлүүдэд түшиглэн, “ХХ зууны Монгол түүхийн зангилаа асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг явуулах. Чингээд академич Ш.Нацагдоржийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд дараах асуудлыг хөндөж тавивал ямар вэ гэсэн санал дэвшүүлэв. Тухайлбал:

1. ХХ зуунд Монголд гарсан улс төрийн 3 томоохон үйл явцыг залгамж чанар, харилцан шүтэлцээнд нь суурилуулах гаргаж тавих (төрийн хар хайрцагны бодлогыг залгамж холбоонд нь гаргах)

2. ХХ зууны Монголын түүхийн үечлэлийг юуны түрүүнд эргэн харах

3. XX зууны Монголын түүхийн хүрдийг эргүүлэлцэж явсан түүхт хүн, хүний асуудлыг дахин эргэцүүлж судлах;

4. Энэ үеийн түүхийн сурвалж бичгийн судалгааг шинэ шатанд гаргах

5. Түүх бичлэгт өөрчлөлт хийх шинэлэгээр хандсан илтгэлүүд тавигдвал үр өгөөжтэй байх болов уу гэж санаж байна гэв.

Ярилцлага семинарт дэд профессор З.Лонжид: Ирэх хичээлийн жилд Монгол Улсын түүхийн 5 боть зохиолын V ботийн талаар профессор багш, судлаачдын санал авах ярилцлага зохион байгуулах, профессор З.Баасанжав: XX зууны Монголын түүхийг заах арга зүйн асуудлыг боловсруулах, дэд профессор Ц.Гантулга: XX зууны Монголын түүхийн сурвалжийн судалгааг гүнзгийрүүлэх, профессор, доктор (Sc.D) Ц.Жамбалсүрэн: XX зууны Монголын түүхийн асуудлуудыг арга зүйн шинэлэг хандлагаар авч үзэх, академич Ж.Болдбаатар: IX сард зохион байгуулах хуралд манай тэнхмээс салбар хуралдааны гол илтгэлийг тавих, тухайлбал, С.Отгонжаргал багш гол илтгэлийг тавих, харин би бүгд хуралдааны нэг гол илтгэлийг “1990-ээд оноос хойш Монголын түүхийн судалгаанд гарсан өөрчлөлт, шинэчлэл” гэсэн сэдвээр хийх бодолтой байгаа тухай ярив. Семинар-ярилцлагад үг хэлсэн профессор багш нар тодорхой сэдвээр ийм ярилцлага үе үе зохиож байх нь чухал болохыг тэмдэглэлээ. Уг семинар-ярилцлага сургалт, судалгааны хувьд үр өгөөжтэй болж өнгөрлөө.